

Б.Мягмарсайхан

Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийн багш

ХЭЛНИЙ БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДЛУУД

Abstract: *The author critically analyses current condition of language study in Mongolia and mentioned a necessity of development of Sociology of language. The author brings an experience and examples of some foreign countries in term of language policy and considers of Mongolian legal environment of language study. The author defines a possible subject matter and approaches of sociology of language and promotes its development.*

Key words: *language, Mongolia, study, sociology, development.*

XIX зууны үеэс хэл шинжлэлийн шинжлэх ухаан хэлний үзэгдлийг судлах болж улмаар сэтгэл судлал, философи, ёс зүй, гоо зүй, соёл судлал, түүх, боловсрол судлал, антропологийн шинжлэх ухаанууд хэлний бүтэц, гарвал түүх, хөгжил, хэлний төрөл зүйл, ялгаа, үгсийн сан, хэлний найруулга зүй, утга төгс байдал, хэл эзэмших үйл явц, хэлний дурсгалууд гээд хэлний холбогдох шинж талаас судлаж ирсэн билээ. Мөн социологийн шинжлэх ухаан нь олон тооны салбар чиглэлээр /50 гаруй/ хөгжиж байгаагийн нэг нь хэлний социологи юм. Хэлний социологийн судалгааны асуудлуудыг соёлын социологи, үндэстэн угсаатны социологи, боловсролын социологи, бие хүний социологи, жендэрийн судалгааны чиглэлүүдэд тусган судлаж байсан юм. Хэл нь сонирхолтой социаль үзэгдэл бөгөөд хэлний нийгмийн шинжүүдийг дурдвал: Хэл бол сэтгэхүйн илэрхийлэл. Хэл нийгмийн харилцааны гол хэрэгсэл. Хэл нь хүний олдмол шинж. Хүний нийгэмшлийг илэрхийлэх нэг шинж бол хэлний чадвар. Хэл нь нийгмийн нөлөөн дор байдаг. Хэл нь үндэстэн угсаатны гол шинж. Соёлын гол бүрэлдэхүүн нь хэл.

1960 оноос хэлний асуудлуудыг социологийн шинжлэх ухааны үүднээс судлах судалгаа эхэлсэн. Хэлний социологийн чиглэлийн суурийг Пенсилваны их сургуулийн профессор Жошуа Фишманы /Joshua A.Fishman/ бүтээлүүд тавьсан. Тэрээр “Хэлний социологи: нийгмийн шинжлэх ухаануудын хамаарал” /1972/, “Хэлэн дэх нийгэм соёлын нөлөө” /1980/, “Хэлний социологийн хөгжил бүтээлүүд” /1980/, “Хэлний цөөнхийн хос хэлний боловсрол” /1983/, “Хэлний төлөвлөлт: олон улсын туршлага” /1983/, “Хос хэл, олон хэлний нэвтэрхий толь” /1998/ бүтээлүүд зэрэг 1000 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт зохиол, бүтээлүүдийг туурвижээ. Ж.Фишман нь үндэсний цөөнхийн хэл соёл, хэл ба шашин, хэлний төлөвлөлт-нийгмийн бодлого, мартагдаж буй хэлүүдийг сэргээх чиглэл, олон хэлний /multilingualism/ харилцаа холбоо, АНУ дахь гадаад оюутнуудын хос хэлний /bilingualism/ боловсрол, еврей хэлний түүх зэрэг судалгааны чиглэлүүдээр ажиллахын хамт “Хэлний социологи” олон улсын сэтгүүлийг үндэслэн эрхлэгчээр ажиллаж байна.

Хэлний социологийн үндсэн асуудлууд нь хэлний хөгжил, өөрчлөлт, хэлний социаль үүрэг, хэлний нийгэмшил, хэлний хэрэглээний хэм хэмжээ, нийгмийн үйлчилгээ, зохицуулалт, социаль орчны нөлөө, хэл соёлын харилцан нэгдэл, нийгмийн бүлгүүдийн хэл /үндэстэн ястан, мэргэжлийн бүлэг, анги давхарга, насны бүлэг, үе, орон нутгийн онцлог бүхий бүлгүүд/ хэлний төрөл зүйлүүд, эх хэл, гадаад хэл, ярианы этгээд хэлбэр, харилцааны зөрчил хэлээр илрэх байдал, хэлний эрх, нэр хүнд, статус, хэлний бодлого, төлөвлөлт, нийгмийн институтын хамаарал зэрэг болно.

Өнөөдөр хэлний социологийн судалгаанд хэлний өөрчлөлт, мөхөж буй хэлний судалгаа, доминант хэлний судалгаа, олон хэлний болон хос хэлний хөгжил, хэлний бодлогын судалгаа, жендэрийн бүлэг зэрэг нийгмийн бүлгүүдийн хэлний онцлог зэрэг судалгааны чиглэлүүд тэргүүлэх чигтэй байна. Дэлхийн нийгэм, эдийн засаг, техник технологи, сэтгэлгээ, аж төрөх ёсны хурдацтай хөгжил нь хэлний үзэгдлүүдэд зайлшгүй нөлөөлж байгаагийн нэг илрэл нь хэлний өөрчлөлт юм. Шинжлэх ухааны судалгааны шинэ талбарыг бий болгож байгаа хэлний өөрчлөлт нь дараахи байдлаар илэрч байна. Үүнд:

1. Хэл зүйн өөрчлөлт /Үгсийн сан, хэлний бүтэц, дуудлага, хэрэглээний хэлбэр ихээр хувьсаж байгаа ба эх хэлнийхээ үгсийн сан, төрөлх байдлыг хадгалах, гадаад үг, хэллэгийн хүчтэй нөлөөг зохицуулах нь олон улс орны хувьд тулгамдсан асуудал болоод байна./
2. Хэлээр харилцагчид, яригчдын өөрчлөлт /Эх хэл, хос хэл, гадаад хэлний түвшинд хэрэглэгчид өөрчлөгдөж байна. Ж нь: англи хэлээр яригчдыг энэ байдлаар авч үзвэл эх хэлний түвшинд 340-380 сая хүн, хос хэлний түвшинд 150-300 сая хүн /Сингапур, Малайз, Энэтхэг/, гадаад хэлний түвшинд 1 тэрбум гаруй хүмүүс ярьж, хэрэглэж байна/
3. Хэлний хэрэглээний хүрээ, орчин өөрчлөгдөж байна. /Орон нутгийн хэл, үндэстний хэл, бүс нутгийн хэл, олон улсын харилцаан дах хэлний өөрчлөлтийг энд багтаан ойлгоно. Ж нь: ASEAN-ний гишүүн орнууд хоорондын харилцаа холбоогоо улам сайжруулахад англи хэлний үүргийг чухалчилж, англи хэлийг судлан шинжлэх төвийг байгуулах нь зүйтэй гэж үзсэн явдал юм.

Хэлний өөрчлөлтийн нэг хэлбэр нь хэл мөхөж буй явдал юм. Нийгэм сэтгэл зүйн нөлөө, хотжилт, шилжилт хөдөлгөөн, зонхилох хэл соёлын нөлөө, үндэсний бичиг үгсийн хэрэглээ, уламжлалт шашин, соёлын олон хэв шинж хумигдах, өрнийн соёл, харь үгийн хүчтэй нөлөө гээд олон хүчин зүйлээс шалтгаалан олон үндэстэн, ястаны хэл мартагдаж, үгүй болоход хүргэж байна. Судлаач Майкл Краус “Дэлхийн хэлний хямрал” бүтээлдээ хэлийг

1. Оршин тогтнох чадвартай хэл
2. Оршин тогтнох чадвартай жижиг бүлгийн хэл
3. Мөхөх аюулд буй хэл
4. Мөхөж байгаа хэл
5. Мөхөж үгүй болсон хэл гэж ангилсан бол

Стивен Вун /Stephen Wurm/ мөхөж буй хэлнүүдийг дараахи байдлаар ангилсан¹ байна.

1. Мөхөж болзошгүй хэл: нийгэм, соёлын анхаарал суларсан хэл
2. Мөхөж буй хэл: хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид мартаж буй хэл
3. Ноцтой байдалд буй хэл: 50 дээш насныхан ярьж буй хэл
4. Мартагдаж буй хэл: өндөр настантууд л ярьж буй хэл
5. Мөхөж үгүй болсон хэл: яригчгүй болсон хэл

Монгол хэл нь дэлхийн хэлний бүлгийн алтай хэлний бүлэгт² бие даасан байрыг эзлэдэг. Монгол хэл нь 1. Халх: дархад, дарьганга, хотгойд, илжгэн, сартуул аялгуу 2.Буриад: хорь, ага, барга, цонгоол, алаар аялгуу 3. Ойрд: дөрвөд, торгууд, өөлд, захчин, баяд, хотон, урианхай аялгуу 4. Өвөрлөгч: үзэмчин, ордос, цахар, барга, харчин, хорчин, урад аялгуунаас бүрддэг. Майкл Краусын ангилалаар авч үзвэл монгол хэлний бүлгийн ойрд, буриад хэл нь “мөхөж байгаа хэл”-ний ангилалд орж байна. Өнөөдөр хүн амын 90 хувь нь халх аялгаар ярьж байгаа ба төв бараадаагүй, хөдөө орон нутагтаа үлдсэн цөөнх ахмадууд, өндөр настнууд л ястан угсаатны хэлээ халх аялгуунд уусгалгүй хадгалж байгаа бол залуучууд нь нутгийн аялга, ястан угсаатны онцлогтой хэл, аялгаар ярих гэж мэрийхээ байсан байна.

Өнөөдөр дэлхий дахин хэлний бодлого, хэлний хурдацтай өөрчлөлт хувьсал, хэлний мөхлийн асуудлуудад анхаарлаа хандуулан олон талт үйл ажиллагаагаа институтчилж байна. 1993 оны 11 сард НҮБ-ын Ерөнхий Ассемблейн хуралдаанаас “Мөхөж буй хэлнүүдийг хамгаалах төсөл “-ийг хэрэгжүүлэх шийдвэр гарч, хэдэн сарын дараа UNESCO “Мөхөж Буй Хэлний Улаан Ном”-ыг гаргасан нь дэлхийн улс орнуудыг энэ асуудалд анхаарлаа хандуулахад дэмжлэг болсон ба энэ чиглэлээр 20 гаруй олон улсын байгууллагууд ажиллаж байна. “Мөхөж буй хэлнүүдийг хамгаалах Олон Улсын Төв” Токиогийн Их Сургуульд, “Устаж буй хэлний сан” АНУ-д, “Мөхөж буй хэлний сүлжээ” Авсралийн Үндэсний Их Сургуульд байгуулагдан ажиллаж байна.

Нийгмийн хөгжлийн хурдацтай нөлөө хэл оршин байхад олон талаар нөлөөлж олон орнууд анхаарлаа хандуулж байгаагийн илэрхийлэл нь 2003 оныг Европын орнууд, 2005 оныг АНУ, 2007 оныг ОХУ “Хэлний жил” болгон зарлаж нийгмийг хамарсан өргөн цар хүрээтэй ажил зохиосон бол НҮБ-ийн Ерөнхий ассамблей 2008 оныг “Дэлхийн хэлний жил” болгон зарласан юм. Мөн улс орон болгон хэлний бодлогын асуудлуудыг хуульчлан зохицуулж байгаа ба дэлхий дээр 125 гаруй улсын үндсэн хуулиндаа хэлийг албан ёсны болон үндэстний хэл

¹ David Crystal. Language death. Cambridge University Press. 2000.

² The Languages of the World. Kenneth Katzner. 2002.

болохыг зааж, Франц, Канад, ОХУ, Хятад, Бельги, Швед, Итали, Мексик зэрэг орнууд хэлний бие даасан хуультай байна.

Хэлийг хуульчлах нь хэлний статусыг тогтоох, хэрэглэх нөхцөлийг тодорхойлох, хэлний хэрэглээг боловсронгуй болгох, үндэсний цөөнхийн хэлийг хамгаалах, хэлний дурсгал, үнэт шинжийг хадгалах, хэлний зөрчил гажуудалуудыг хориглох, албан ёсоор хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулах зэрэг олон зорилготой юм. Монгол Улсын Үндсэн хуульд монгол хэлийг төрийн албан ёсны хэл мөн болох статусыг тогтоон, хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийг эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг тусгаж өгсөн юм¹. Мөн “Үндэсний Аюулгүй Байдлын тухай хууль”-д /2001/ оршин тогтнохын аюулгүй байдал, соёл иргэншлийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал зэрэг чиглэлүүдээр хэл соёлын бие даасан байдлыг хадгалах талаар тодорхой тусгасан². “Соёлын тухай хууль”-д, “Соёлын Өвийн тухай хууль”-д эх хэл, бичиг үсгээ сурах, сургах, өвлөх, өвлүүлэх, хөгжүүлэх, элдэв халдлагаас сэрэмжлэн хамгаалах тухай заасан. Эх хэлний хэрэглээг боловсронгуй болгох, эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор УИХ 2003 онд “Төрийн албан ёсны хэлний хууль”-ийг батлан хэрэгжүүлж байна. Төрийн албан ёсны хэлний хэрэгжилтийг хангах нэгж нь Төрийн хэлний зөвлөл байна. Хэлний харилцааны олон асуудал энэ байгууллагын үйл ажиллагаанаас хамаарч байна.

Манай оронд хувьсгал ялсны дараа Судар Бичгийн Хүрээлэнг /1925 онд/ байгуулж түүний дэргэд нэр томъёоны асуудал эрхэлсэн салбарыг бий болгосон нь Улсын нэр томъёоны комисс билээ. Улсын нэр томъёоны комисс нь орчин цагийн шинжлэх ухаан техникийн зуун хорин мянга гаруй нэр томъёог оноон тогтоож хэвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 1990 оны жилүүдэд энэ байгууллагын үйл ажиллагаа саарсан ба 2003 онд “Төрийн албан ёсны хэлний тухай хууль” батлагдсанаар УНТК-ийн үүргийг Төрийн хэлний зөвлөл, түүний нэр томъёоны салбар зөвлөл гүйцэтгэх болсон юм. Өнөөдөр ШУА-ийн Утга Зохиолын Хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн сектор энэ зөвлөлийн үүргийг гүйцэтгэж нэр томъёог оноон тогтоох, оновчтой болгох толилох, жигдлэх ажлыг эрхлэн хариуцаж байна. Бид энэ байгууллагын ажлаар зогсохгүй шинжлэх ухаан бүрийн эрдэмтэдийн бүлэг өөрсдийн санаачлагаар салбарынхаа ойлголт ухагдахуун, нэр томъёоны судалгаа, манайд хэрэглэгдэж буй гажуудалуудад дүн шинжилгээ хийн мэргэжлийн бүлгийн зөвшилцөлөөр энэ танин мэдэхүйн бэрхшээлийг даван туулах нь зүйтэй ба их сургуулиуд ч энэ ажилд дэмжлэг үзүүлэх шаардлагатай юм. Оюутан суралцагсдад мэргэжлийн нэр томъёоны тайлбар толь, орчуулгын толь, ойлголтын хувьд зөрчилгүй сурах бичиг, мэргэжлийн сэтгүүл, эрдэм шинжилгээний бичвэр, бүтээлүүд маш их хэрэгцээтэй байна.

Хоёр туйлт систем нь орос хэл төвтэй социалист системийн орнуудад өрнийн хэлний хэрэглээг хязгаарлаж байсан билээ. Монгол Улс 1990-ээд оныг хүртэл хязгаарлагдмал гадаад харилцаатай, хүн амын гадаад хэлний хэрэгцээ үндсэндээ орос хэлээр хангагдаж байсан бол өнөөдөр гадаад хэлний хэрэгцээ хэрхэн өргөжсөнийг авч үзье. Сүүлийн үеийн судалгааны дүнгээр орос хэлийг 700 гаруй сургуулиудад 600000 хүүхэд, солонгос хэлний ангитай 10 гаруй их дээд сургууль, 6 дунд сургуульд 4000 гаруй оюутан сурагчид, хятад хэлний 25 их, дээд сургууль, 14 дунд сургуульд 3000 гаруй хүн, япон хэлийг мөн 40 гаруй сургуульд 9000 гаруй хүн, франц хэлийг 370 сурагч 6 сургуульд сурч байна. Улс орнуудын гадаад хэлний бодлого ч шинэчлэгдэж байна. Англи хэлэнд хандах хандлага ч өөрчлөгдөж байгаа ба “EFL” /English as a Foreign Language/ буюу “Англи хэлийг гадаад хэл” гэж үзэх хандлагаас “ESOL” /English for Speakers of Other languages/ “Бусад хэлээр яригчдад зориулсан англи хэл” гэсэн хандлага уруу чиглэж байна.

Манай орны хувьд хэлний бодлого төлөвлөлтийн ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхийн өмнө олон нийтийн санал бодол, эрдэмтэд, мэргэжлийн холбоо бүхий байгууллагуудын байр суурийг харгалзан дэмжлэг авахын тулд хэлний хэрэглээ, хэлэнд хандах монголчуудын хандлагын талаар суурь судалгааны хэрэгцээ гарцаагүй байна. Үндэсний монгол бичиг, кирил үсэг, латин үсэг, гадаад хэлний хөтөлбөрүүдийг харилцан уялдаатай нэгдсэн болгох, боловсролын байгууллага, хэвлэл мэдээлэл, захиргааны болон үйлчилгээний байгууллагууд зэрэг хэрэглээний тодорхой салбаруудад хэлний бодлогыг чанд мөрдөн ажиллавал энэ байдал цэгцрэх нь зайлшгүй юм. Мөн үйл ажиллагааны түвшинд дараахи зүйлст анхаарах зүйтэй байна. Үүнд:

¹ Илгээ Оёһүг Тһһүг Додоёу. 1992.й 1эзёүа. 8.1,18.2

² Тһүггёе Арёёзэ Аёёёүг Додоёу. 2001 й.

- Монгол хэлний дүрмийн ном, латин үсгийн дүрэм, гадаад үгийн толь, тайлбар толь, кирил-латин үсгийн дундын дүрэм, харьцуулсан толь бичиг, товчилсон үгийн толь
- Хэлний дурсгалуудыг хадгалах, хэлний соёлд суралцах орчин бүрдүүлэх
- Эх хэлний болон гадаад хэлний багш нарыг сургалт, арга зүйн удирдлагаар хангах
- Хэлний сургалтад электрон номын сан, интерактив хэрэглэгдэхүүн, сургалтын виртуал орчин, технологийн нөхцлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх
- Гадаад хэлний цэцэрлэг, ЕБС, их, дээд сургуулиудын үйл ажиллагааг уялдуудах
- “Төрийн албан ёсны хэлний тухай хууль”-ийг хэрэгжүүлэх
- Хэлний судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудыг дэмжих
- Шинжлэх ухааны нэр томъёог оноон тогтоох, жигдрүүлэх, мөрдүүлэх, хэвшүүлэх
- Ойлгомжтой, энгий хэлний зарчмыг албан бичгийн стандартад тусгах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, орчуулгын ном бүтээлүүд, интернетийн сайтуудад зөвлөх
- Хэлний богино хугацааны сургалтын төв, орчуулгын товчоодуудын үйл ажиллагааг хянах

Ном зүй

1. International act
 - UNESCO. World Languages Report
 - Resolution on the languages and cultures regional and ethnic minorities in the European Community /1987/
 - United Nations Declaration on the Rights of persons Belonging to National or ethnic religious and Linguistic Minorities /1992/
 - Resolution on Linguistic and Cultural Minorities in the European Community /1994/
2. Хууль: www.legalinfo.mn
 - Монгол Улсын Үндсэн хууль.1992.он
 - Үндэсний Аюулгүй Байдлын тухай хууль. 2001 он.
 - Төрийн албан ёсны хэлний тухай хууль. 2005 он
 - Соёлын тухай хууль. 2000 он
 - Соёлын өвийн тухай хууль. 2001он
 - Боловсролын тухай хууль /2002/
3. Монгол Улсын Хэлний бодлого. УБ., 2006
4. Монгол Улсын Боловсролын салбарын хэлний бодлого. УБ., 2007
4. Даяарчлалыг зөийн үндэсний хэл ба гадаад хэл. УБ.,2007
5. David Crystal. Language death. Cambridge. 2000
6. Kenneth Katzner. The Languages of the World. 2002.
7. David Crystal. Encyclopedia of language. Cambridge. 2000.
8. Andrew Dalby. Language in danger. 2002
9. Sociolinguistics: An introduction to language and society.2000